



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу, Утас: 7012 0013, <http://www.msue.edu.mn>

ТАНАА

2021.02.26 № 1/19
танай _____-ны № _____-г

Хурлын зар хүргэх тухай

МУБИС нь “Тэгш хамруулах ба тусгай хэрэгцээт боловсролын бодлого, практик үйл ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 16-нд зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Тус эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улсад тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсролын бодлого, практик үйл ажиллагааны хүрээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдэх арга зам, орчин үеийн чиг хандлага, инновацийн талаар багш, эрдэмтэн, судлаач нарын санаа бодол, арга туршлага, судалгааны үр дүнг хэлэлцэх зорилготой болно.

Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцэх өгүүллийг 2021 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн 17 цаг хүртэл хүлээн авах бөгөөд шалгуурт нийцсэн өгүүллийг хэлэлцүүлж, эмхэтгэн хэвлэн нийтэлнэ. Хавсралтад сэдвийн хамрах хүрээ, өгүүлэлд тавигдах шаардлага зэргийг тусгасан болно. Та бүхэн практик үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээ танилцуулж, хэлэлцүүлэн тус салбарын хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулж, идэвхтэй оролцоно уу. Удирдамжийг хавсралтаас харна уу.

Тус эрдэм шинжилгээний хурлыг МУБИС-ийн 70 жилийн ойн баярыг угтан зохион явуулж байгаагаараа онцлог юм.

Өгүүлэл хүлээн авах хаяг: inclusive.edu2021@gmail.com

Холбоо барих утас: 99008074

ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР



Г.ЦОГЗОЛМАА

20210038

**“ТЭГШ ХАМРУУЛАХ БА ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО,
ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГАА” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН
УДИРДАМЖ**

Ерөнхий зохион байгуулагч: МУБИС-ийн Боловсрол судлалын сургууль, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим

Хугацаа: 2021 оны 4 дүгээр сарын 16-нд МУБИС дээр зохион явуулна.

Оролцогчид:

- Их дээд сургуулийн багш, мэргэжилтнүүд
- Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн багш нар
- Тусгай цэцэрлэг болон сургуулийн үндсэн болон туслах багш нар
- Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан, мэргэжилтнүүд, судлаачид
- Магистрантур, докторантурт суралцаж буй судлаач оюутнууд

Үндэслэл:

Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд, залуучууд бусдын адил бүх шатны боловсролын үйлчилгээ авах эрхтэй бөгөөд тус эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэхэд улс орон бүр анхаарал хандуулсаар байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улс тэгш хамруулах боловсролын үзэл санааг хэрэгжүүлэх, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэн, сайжруулах чиглэлээр тодорхой алхмуудыг эхлүүлсэн. Хөгжин шинэчлэгдэж буй тус салбарын хүрээнд олон асуудал бэрхшээл тулгарч байгаа бөгөөд тэдгээрийг илрүүлэх, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлж, туршин судлах, хамтран хэлэлцэх хэрэгцээ шаардлага бидэнд үүсч байна. Тиймээс бид тус салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах үүднээс эрдэмтэн багш нар, судлаачдыг хамруулан энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн болно.

Зорилго:

Монгол Улсад тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсролын бодлого, практик үйл ажиллагааны хүрээнд тулгамдаж буй асуудал, бэрхшээл, тэдгээрийг даван туулах орчин үеийн арга хандлага, инновацийн талаар багш, эрдэмтэн, судлаач нарын санаа бодол, туршлага, судалгааны үр дүнг хэлэлцэх

Гарах үр дүн:

Тус эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулснаар тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсролын бодлого, түүний хэрэгжилт, практик үйл ажиллагааны тулгамдсан асуудлууд, тэдгээрийг даван туулж буй өөрийн болон бусад улс орны сайн туршлага, шийдвэрлэх боломж, арга зам зэргийг хамарсан судалгаа, шинжилгээ, нотолгоонд тулгуурласан сүүлийн үеийн баримт мэдээллийн багц бий болно.

ЭШХ-д хэлэлцүүлсэн судалгааны ажил, илтгэл, өгүүлэлд тулгуурлан тус салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах бодлого, эрх зүйн шинэчлэл, практик үйл ажиллагааны шинэлэг санаа, сайн туршлага, инноваци, арга зүйг нэгтгэсэн зөвлөмж гарна.

Эдгээрийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЭШХ-ын эмхэтгэлийг хэвлэн нийтэлнэ. Хурлын эмхэтгэлийг мэргэжлийн олон нийт, төрийн болон төрийн бус

байгууллагын мэргэжилтнүүд, оюутан суралцагч, судлаачид өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэглэж ашиглана.

Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэгдэх сэдвүүд:

- Тэгш хамруулах ба тусгай хэрэгцээт боловсролын бодлого, хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилт
- Тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсролын онолын асуудал, практик үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал бэрхшээл, шийдвэрлэх арга зам, сайн туршлагаууд
- Тэгш хамруулах боловсрол ба хамтын ажиллагаа
- Тэгш хамруулах боловсролын үйлчилгээн дэх салбар дундын үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлага, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам
- Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн инноваци
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд судлалын асуудал, судалгааны арга зүй

Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага:

- Эрдэм шинжилгээний өгүүлэл нь хураангуй, түлхүүр үг, үндсэн хэсэг, судалгааны хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн бүтэцтэй байна.
- Өгүүллийг 5-8 нүүрэнд багтаана. Цаасны хэмжээ А4, үсгийн фронт arial, үсгийн өндөр 11, мөр хоорондын зай 1.15 байх ба хуудасны дээд, доод, баруун, зүүн талд 2.54 см зай авна. Хуудсыг дугаарлахгүй.
- Сэдэв буюу гарчгийг хуудас голлуулан том үсгээр бичнэ.
- Гарчгийн доор овог нэр, ажлын газар, цол зэрэг, e-mail хаяг, холбогдох утасны дугаарыг бичнэ.
- Илтгэлийн дэд хэсгүүдийг bold-оор бичсэн байна.
- Хураангуйг 4-6 мөрөнд, түлхүүр үгийг 3-5 үгэнд багтаан бичнэ.
- Хүснэгт, зургийн гарчгийн үсгийн өндөр 10 байх ба хүснэгт доторх текстийн үсгийн өндөр 8 байна.
- Өгүүллийн ишлэл, зүүлт, ном зүйг APA загварын дагуу бичнэ.

Эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах:

- Хуралд оролцогчдын эрдэм шинжилгээний бүтээлийг цахим хэлбэрээр 2021 оны 04 дүгээр сарын 9-ны дотор inclusive.edu2021@gmail.com хаягаар хүлээн авна.
- Мэйл илгээхдээ зохиогч өөрийн нэр, хаяг, утасны дугаарыг тодорхой бичсэн байна.
- Шаардлагад нийцсэн өгүүллийг эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлнэ.
- Хурлаар хэлэлцүүлэхээр сонгогдсон өгүүллийг зохиогчдод урьдчилан мэдэгдэнэ.
- Хуралд өгүүлэл хэлэлцүүлсэн оролцогчдод гэрчилгээ олгох ба эхний 3 байранд орсон оролцогчдод өргөмжлөл гардуулна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

